

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 11 дүгээр цэцэрлэг 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/77/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дархан-Уул аймаг 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ч.Мөнхбаяр Утас: 89275858 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	3
Аудитын гол асуудал.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	19
5.1 Төлбөрийн акт.....	18
5.2 Албан шаардлага.....	19
5.3 Зөвлөмж .....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН УУЛ АЙМГИЙН 11 ДҮГЭЭР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
А.СОЁЛМАА ТАНАА

2025.02.25 № 84

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна. □

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант хугацаанд Боловсрол, шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар 13,408.5 мянган төгрөгийн компьютер, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 8,340.0 мянган төгрөгийн аяга таваг угаагч хүлээн авч, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, тайлагнасан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 589,538.5 мянган төгрөг болж, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 47.9 хувиар өссөн байна.

### **Бусад асуудал**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан Уул аймгийн Дархан сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилтын хүрээнд 63 хөтөлбөр арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 98.8 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр Боловсрол газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.МӨНХБАЯР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	133,102,512.56	163,203,509.15
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	105,164,341.00	142,964,158.43
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	105,164,341.00	142,964,158.43
3121	Төгрөг	105,164,341.00	142,964,158.43
31211	Төрийн сангийн харилцах	105,164,341.00	142,964,158.43
314	Замд яваа мөнгөн хөрөнгө		
33	АВЛАГА		
34	УРЬДЧИЛГАА		
35	БАРАА МАТЕРИАЛ	27,938,171.56	20,239,350.72
354	Хангамжийн материал	27,938,171.56	20,239,350.72
3541	Бичиг хэргийн материал	153,580.00	501,480.00
3542	Аж ахуйн материал	18,553,982.06	18,061,723.92
3546	Хүнсний материал	9,230,609.50	1,676,146.80
36	НӨӨЦИЙН БАРАА		
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	903,343,615.92	895,210,875.34
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	903,343,615.92	895,210,875.34
392	Биет хөрөнгө	780,409,615.72	772,276,875.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	744,618,440.00	744,618,440.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(52,319,447.88)	(68,348,517.60)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	41,190,983.00	66,776,383.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(14,766,415.94)	(21,541,924.53)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,768,341.20	32,661,561.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,730,111.63)	(15,251,830.52)
39214	Бусад үндсэн хөрөнгө	86,684,420.00	86,684,420.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(44,580,863.03)	(53,865,926.51)
39217	Ном	544,270.00	544,270.00
393	Биет бус хөрөнгө	122,934,000.20	122,934,000.00
39301	Програм хангамж	1,124,300.00	1,124,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,124,299.80)	(1,124,300.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	122,934,000.00	122,934,000.00

ХТӨ6430@9022000


III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,036,446,128.48	1,058,414,384.49
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
413	Өглөг		
414	Урьдчилж орсон орлого		
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
422	Урт хугацаат зээл		
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,036,446,128.48	1,058,414,384.49
51	Засгийн газрын хувь оролцоо	1,036,446,128.48	1,058,414,384.49
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	122,934,000.00	122,934,000.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	122,934,000.00	122,934,000.00
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	913,512,128.48	935,480,384.49
5121	Өмнөх үеийн үр дүн	913,512,128.48	913,512,128.48
5122	Тайлант үеийн үр дүн		21,968,256.01
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,036,446,128.48	1,058,414,384.49




## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	706,202,912.00	903,040,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	32,282,330.00	22,298,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	32,282,330.00	22,298,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	70,000.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	25,007,350.00	21,748,500.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	7,204,980.00	550,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	673,920,582.00	880,742,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	648,645,300.00	831,243,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	648,645,300.00	831,243,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	25,275,282.00	49,498,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,275,282.00	49,498,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	619,363,194.37	881,072,643.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	619,363,194.37	881,072,643.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	607,820,993.61	860,893,785.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	398,463,157.91	589,538,512.38
210101	Үндсэн цалин	285,467,261.80	408,087,122.06
210102	Нэмэгдэл	98,725,940.45	153,674,841.59
210104	Урамшуулал	14,269,955.66	27,776,548.73
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,852,418.40	77,853,680.19
210201	Тэтгэврийн даатгал	35,698,577.81	54,907,910.30
210202	Тэтгэмжийн даатгал	4,184,725.99	5,994,072.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,286,463.99	2,891,486.43
210204	Ажилгүйдлийн даатгал	788,690.67	2,812,041.72
210205	Эрүүл мэндийн даатгал	7,893,959.94	11,248,169.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,975,281.24	23,686,341.19
210301	Гэрэл, цахилгаан	7,921,610.48	7,642,243.87
210302	Түлш, халаалт	9,790,887.48	9,965,479.44
210303	Цэвэр, бохир ус	6,262,783.28	6,078,617.88
2104	Хангамж, бараа материалын зардал	5,960,930.00	18,256,883.74
210401	Бичиг хэрэг	3,666,180.00	10,854,145.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	118,350.00	284,880.00
210408	Бараа материал акталсны зардал	2,176,400.00	7,117,858.14
2105	Нормативт зардал	69,998,307.50	80,059,427.10



210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	275,000.00	293,000.00
210502	Хоол, хүнс	69,723,307.50	79,766,427.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,198,980.00	22,219,600.00
210604	Урсгал засвар	10,198,980.00	22,219,600.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	397,000.00	2,055,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	397,000.00	2,055,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,974,918.56	47,224,140.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,770,222.68	10,381,000.00
210902	Хичээл үйлдэрлэлийн дадлага хийх	1,770,000.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,434,695.88	36,843,140.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,542,200.76	20,178,858.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,542,200.00	16,865,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,542,200.00	16,865,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.76	3,312,958.81
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.76	3,312,958.81
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
	Дотоод эх үүсвэрээр		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	86,839,717.63	21,968,256.01
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	86,839,717.63	21,968,256.01




## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	673,990,582.00	880,742,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	70,000.00	
120	Нийтлэг татварын бус орлого	70,000.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	70,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	673,990,582.00	880,742,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	648,645,300.00	831,243,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	648,645,300.00	831,243,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	25,275,282.00	49,498,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,275,282.00	49,498,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	574,626,855.99	835,980,682.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	574,626,855.99	835,980,682.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	563,084,655.23	815,801,823.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	398,463,157.91	589,538,512.38
210101	Үндсэн цалин	285,467,261.80	408,087,122.06
210102	Нэмэгдэл	98,725,940.45	153,674,841.59
210104	Урамшуулал	14,269,955.66	27,776,548.73
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,852,418.40	77,853,680.19
210201	Тэтгэврийн даатгал	35,698,577.81	54,907,910.30
210202	Тэтгэмжийн даатгал	4,184,725.99	5,994,072.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,286,463.99	2,891,486.43
210204	Ажилгүйдлийн даатгал	788,690.67	2,812,041.72
210205	Эрүүл мэндийн даатгал	7,893,959.94	11,248,169.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,975,281.24	23,686,341.19
210301	Гэрэл, цахилгаан	7,921,610.48	7,642,243.87
210302	Түлш, халаалт	9,790,887.48	9,965,479.44
210303	Цэвэр, бохир ус	6,262,783.28	6,078,617.88
2104	Хангамж, бараа материалын зардал		
2105	Нормативт зардал	68,589,815.00	72,575,240.00
210502	Хоол, хүнс	68,589,815.00	72,575,240.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,300,000.00	22,499,600.00
210604	Урсгал засвар	1,300,000.00	22,499,600.00
2107	Томилолт, зочны зардал		1,150,600.00
210702	Дотоод албан томилолт		1,150,600.00

ХТ0543009021099

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,178,600.00	2,555,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,178,600.00	2,555,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,725,382.68	25,942,650.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,173,982.68	17,514,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,551,400.00	8,428,250.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,542,200.76	20,178,858.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,542,200.76	16,865,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		16,865,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.76	3,312,958.81
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.76	3,312,958.81
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	99,363,726.01	44,761,717.43
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	6,115,100.00	6,961,900.00
	Дотоод эх үүсвэрээр	6,115,100.00	6,961,900.00
223001	Бусад хөрөнгө	6,115,100.00	6,961,900.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	6,115,100.00	(6,961,900.00)
145	Бусад эх үүсвэр		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	93,248,626.01	37,799,817.43
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11,915,714.99	105,164,341.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	105,164,341.00	142,964,158.43



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,934,000.00		826,672,410.85	949,606,410.85
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Тайлант үеийн үр дүн			86,839,717.63	86,839,717.63
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,934,000.00		913,512,128.48	1,036,446,128.48
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			21,968,256.01	21,968,256.01
18	.....				
19	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,934,000.00		935,480,384.49	1,058,414,384.49


Handwritten signatures and a red rectangular stamp with the text "ХТ05430 @ 9022899" are present over the table data.

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	985,906,600.00	838,479,023.76	(147,427,576.24)	85.0%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	985,906,600.00	838,479,023.76	(147,427,576.24)	85.0%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	969,040,700.00	814,651,223.76	(154,389,476.24)	84.1%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	713,996,100.00	589,538,512.38	(124,457,587.62)	82.6%
210101	Үндсэн цалин	512,792,200.00	408,087,122.06	(104,705,077.94)	79.6%
210102	Нэмэгдэл	188,979,100.00	153,674,841.59	(35,304,258.41)	81.3%
210104	Урамшуулал	12,224,800.00	27,776,548.73	15,551,748.73	227.2%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,865,500.00	77,853,680.19	(5,011,819.81)	94.0%
210201	Тэтгэврийн даатгал	56,350,000.00	54,907,910.30	(1,442,089.70)	97.4%
210202	Тэтгэмжийн даатгал	6,627,700.00	5,994,072.58	(633,627.42)	90.4%
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,314,600.00	2,891,486.43	(423,113.57)	87.2%
210204	Ажилгүйдлийн даатгал	3,314,600.00	2,812,041.72	(502,558.28)	84.8%
210205	Эрүүл мэндийн даатгал	13,258,600.00	11,248,169.16	(2,010,430.84)	84.8%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,998,900.00	23,686,341.19	(3,312,558.81)	87.7%
210301	Гэрэл, цахилгаан	9,000,000.00	7,642,243.87	(1,357,756.13)	84.9%
210302	Түлш, халаалт	10,858,900.00	9,965,479.44	(893,420.56)	91.8%
210303	Цэвэр, бохир ус	7,140,000.00	6,078,617.88	(1,061,382.12)	85.1%
2104	Хангамж, бараа материалын зардал			-	0.0%
2105	Нормативт зардал	81,960,700.00	72,575,240.00	(9,385,460.00)	88.5%
210502	Хоол, хүнс	81,960,700.00	72,575,240.00	(9,385,460.00)	88.5%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,500,000.00	22,499,600.00	(400.00)	100.0%
210604	Урсгал засвар	22,500,000.00	22,499,600.00	(400.00)	100.0%
2107	Томилолт, зочны зардал	-	1,150,600.00	1,150,600.00	0.0%
210702	Дотоод албан томилолт		1,150,600.00	1,150,600.00	0.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,678,700.00	2,555,200.00	(123,500.00)	95.4%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,678,700.00	2,555,200.00	(123,500.00)	95.4%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,040,800.00	25,942,650.00	(12,098,150.00)	68.2%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,607,700.00	17,514,400.00	(12,093,300.00)	59.2%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,433,100.00	8,428,250.00	(4,850.00)	99.9%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,865,900.00	23,827,800.00	6,961,900.00	141.3%
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,865,900.00	16,865,900.00	-	100.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,865,900.00	16,865,900.00	-	100.0%
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох			-	0.0%
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг			-	0.0%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		6,961,900.00	6,961,900.00	0.0%
	Дотоод эх үүсвэрээр		6,961,900.00	6,961,900.00	0.0%
223001	Бусад хөрөнгө		6,961,900.00	6,961,900.00	0.0%
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	985,906,600.00	877,429,441.19	(108,477,158.81)	89.0%
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	936,407,700.00	831,243,500.00	(105,164,200.00)	88.8%
131001	Улсын төсвөөс санхүүжих	936,407,700.00	831,243,500.00	(105,164,200.00)	88.8%
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого			-	0.0%

132	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>49,498,900.00</b>	<b>46,185,941.19</b>	(3,312,958.81)	93.3%
132001	Орон нутгийн төсвөөс	49,498,900.00	46,185,941.19	(3,312,958.81)	93.3%
133	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС			-	0.0%
134	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ			-	0.0%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС			-	0.0%
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР			-	0.0%
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		105,164,341.00	105,164,341.00	0.0%
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	105,164,341.00	142,964,158.43	37,799,817.43	135.9%
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	0.0%
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00		(1.00)	0.0%
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	87.00	84.00	(3.00)	96.6%
6	Удирдах ажилтан	3.00	3.00	-	100.0%
7	Гүйцэтгэх ажилтан	51.00	48.00	(3.00)	94.1%
8	Үйлчлэх ажилтан	30.00	30.00	-	100.0%
9	Гэрээт ажилтан	3.00	3.00	-	100.0%
10	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	414.00	338.00	(76.00)	81.6%
14	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	208.00	170.00	(38.00)	81.7%
15	Төрийн өмчит СӨБ байгууллага	207.00	169.00	(38.00)	81.6%
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ				
33	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)				



## **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Дархан-Уул аймгийн Дархан сумын 11 дүгээр цэцэрлэг нь хамран сургах тойрог буюу 15-р багийн 2-5 насны 207 хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгож “Хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл, сургалтын үйл ажиллагаа үр дүнтэй зохион байгуулах” гэсэн зорилготой ажиллаж байна.

#### **Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Сангийн сайдын “Аргачлал, зардлын норматив батлах тухай” 2022 оны А/23,27 дугаар тушаал зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 53 дугаар тогтоол “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоол “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоол “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 82 тоот тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 104 тоот тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш ажилтанд мөнгөн тэтгэмж олгох”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 237 тоот тогтоол “Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”,
- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны А/85, А/34 дүгээр тушаал “Орон тооны хязгаарын жишиг норматив батлах тухай”,
- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны 115 тоот дугаар тушаал “Цэцэрлэг, ЕБС-ийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх дүгнэх”

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан Уул аймгийн Дархан сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд өөрчлөлт ороогүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна. Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх НББ-ийн журам”-ыг үндэслэн 2025 оноос Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулж мөрдөж ажиллана.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан Уул аймгийн Дархан сумын 11 дүгээр цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, УСНББОУС -ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21,968.3 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	105,164.30	142,964.20	37,799.90
Бараа материал	27,938.20	20,239.40	(7,698.80)
Үндсэн хөрөнгө	903,343.60	895,210.80	(8,132.80)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,036,446.10</b>	<b>1,058,414.40</b>	<b>21,968.30</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,036,446.10	1,058,414.40	21,968.30
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,036,446.10</b>	<b>1,058,414.40</b>	<b>21,968.30</b>

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 142,964.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 20,239.4 мянган төгрөг болж 7,698.8 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 6,961.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үйл ажиллагаанд 113,418.0 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсныг тайланд бүрэн тусгажээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 895,210.9 мянган төгрөг болж 22,072.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд ДСЗДТГазраас аяга таваг угаагч тоног төхөөрөмж 8,340.0 мянган төгрөг, БШУГазраас багш нарт 7 ширхэг 13,408.5 мянган төгрөгний зөөврийн компьютер, 21,748.5 тоног төхөөрөмж, тавилга зэргийг үнэ төлбөргүй хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 3 ширхэг 6,961.9 мянган төгрөгийн өнгөт принтер, хивсэнцэр, хяналтын камер худалдан авч тус тус бүртгэлд тусгасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,058,414.4 мянган төгрөг болж 21,968.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 726,801.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 49,498.9 мянган төгрөг нийт 998,906.6 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг улсын төсвийг 985,906.6 мянган төгрөг, орон нутгийн төсвийг 46,185.4 төгрөгийг зарцуулж 3,312,9 мянган төгрөгийн хэмнэлттэй ажиллаж төвлөрүүлсэн байна.

Энэ нь өмнөх онуудын гүйцэтгэлд үндэслэн цалингийн зардлыг 191,075.3 мянгаар нэмж, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 26,001.2 мянгаар нэмэгдэж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 289.0 мянгаар хасаж, хоол хүнсний зардал 3,985.5 мянгаар нэмж, бусад зардлыг 9,953.0 мянган төгрөгөөр тус тус нэмсэнтэй холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 880,742.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 49,498.9 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих 105,164.3 мянган төгрөг нийт 985,906.6 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 49,498.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 46,185.9 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 3,312.9 мянган төгрөгийг төвлөрүүлж, улсын төсвөөс 880,742.3 мянган төгрөгийн санхүүжилт, урьд оны үлдэгдэл 105,164.3 мянган төгрөг олгосноос 842,942.6 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 142,964.0 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 842,942.6 мянган төгрөг буюу 85,50 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 142,964.0 мянган төгрөгийн зардлыг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	<b>71801-Сургуулийн өмнөх боловсрол олгох</b>	<b>985,906.6</b>	<b>838,479.0</b>	<b>(147,427.6)</b>	<b>85.5</b>
1.1	80111- Тогтмол зардал	49,498.9	46,185.9	(3,313.0)	93.31
1.2	80233-Хүүхэд хамгаалал	1,251.7	1,249.7	(2.0)	99.88
1.3	81605-Эрүүл мэндийг зардал	1,946.1	1,920.0	(26.1)	98.66
1.4	81807-Хоол хүнс	79,120.4	72,575.3	(6,545.1)	88.55

1.5	81816-Хүүхдэд ээлтэй орчин	3,197.8	3,192.5	(5.3)	99.83
1.6	81823- Багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1,946.1	900.0	(1,046.1)	46.25
1.7	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	811,346.9	676,802.1	(134,544.9)	83.86
1.8	81835-Боловсролын хэвийн үйл ажиллагааг хангах	37,598.7	35,653.5	(1,945.2)	94.83

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Ахмад настны тухай хуулийн 14.7-д “Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална” гэж заасан заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд тус цэцэрлэг нь удирдах 1 ажилтан, гүйцэтгэх 17 ажилтан, үйлчлэх 10 ажилтан, гэрээт 1 ажилтан буюу нийт 29 ажилтантайгаар ажиллаж, 210901-Бараа үйлчилгээний бусад зардалд 14,455.1 мянган төгрөгийг зарцуулж, худалдан авах ажиллагаатай холбоотой гэрээ шууд байгуулахаар 24,650.3 мянган төгрөг, харьцуулалтын аргаар 73,563.1 мянган төгрөгийн ажил, үйлчилгээ төлөвлөж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ч нэг оролцогч ирээгүй байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаа таван удаа харьцуулалтын аргаар зарлаж оролцогч орж ирээгүйн улмаас шууд худалдан авалтыг хийсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан Уул аймгийн Дархан сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн бараа материалтай холбоотой болон шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "ЦЭСБ-Аудит" ХХК-ийн аудитор Ч.Мөнхбаяр гүйцэтгэж анхан шатны хяналтыг захирал Ч.Цэрэннадмид, чанарын менежер Т.Эрдэнэтуяа, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан Уул аймгийн Дархан сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ЦЭСБ-Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны орлого үр дүнгийн тайлангийн сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны хагас жилийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 619,363.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,193.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Дархан Уул аймгийн Дархан сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2024 оны төсвийг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 11 дүгээр зүйл, Засгийн газрын 2016 оны 211 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 194 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

##### **4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах ...." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу “Ахмадын сан” байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллах журам”-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд илрүүлсэн алдаа, зөрчил гараагүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах 881.4 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг 100 хувийн хэрэгжилттэй байна.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	881.4	2	881.4	100
Нийт дүн	2	881.4	2	881.4	100

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Боловсролын ерөнхий газрын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр 775,924.7 мянган төгрөгөөр батлагдсан төсвийн хуваарийг 2024 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 209,981.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр 842,942.6 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй гарч жилийн эцсийн үлдэгдэл 142,964.0 төвлөрсөн тул харилцах дансны үлдэгдэл өсөж төсвийн гүйцэтгэл 85.5 хувьтай гарсан байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,230.8 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэнд 3,088.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 142.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлэв.

##### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогүй болно.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

## **5.2 Албан шаардлага**

5.3.2.1 Илрүүлэлт: Тус цэцэрлэгийн эрхлэгч А.Соёлмаа Дархан-Уул аймгийн БГ-ын даргын А/141 тоот тушаалаар 2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлтээр “өөрчлөлтгүй” гэж дүгнэгдсэнд нэг сарын цалин 2 дахин нэмэгдүүлэн 3,088.0 мянган төгрөгийн балансын урамшуулал авсан нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 тогтоолын “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-тай нийцээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

## **5.3 Зөвлөмж**

### **5.3.2 Бараа материалтай холбоотой асуудал**

5.3.2.1 Илрүүлэлт: Тус цэцэрлэг нь хүүхдийн хоолны материалыг норматив хэмжээнээс 142.8 мянган төгрөгөөр дутуу тооцож зарцуулсан байгаа нь Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2020 оны А/166, А/559, 222 тоот “Норматив батлах тухай” тушаалын 2 дугаар хавсралтын 2.1, 2.2-т заасан “Цэцэрлэгийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ” гэж заасантай нийцэхгүй байна.

5.3.2.2 Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж байх

Дээрхи зөвлөмжөөс гадна тайлангийн 4.4.2 дахь хэсэгт дурдсан Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>2</sup>-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж			
							Залруулсан		Залруулаагүй					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

/мянган төгрөгөөр/

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус цэцэрлэгийн эрхлэгч Х.Отгонтуяаг Дархан-Уул аймгийн БГ-ын даргын А/141 тоот тушаалаар 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлтээр "өөрчлөлтгүй" гэж дүгнэгдсэнд нэг сарын цалин 2 дахин нэмэгдүүлэн 3,088.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон.	1	3,088.0	-	-	1	3,088.0	-	-	-	-	-	-
Тус цэцэрлэг нь хүүхдийн хоолны материалыг норматив хэмжээнээс дутуу тооцож зарцуулсан байна.	1	142.8					1	142.8				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>3,230.8</b>	-	-	<b>1</b>	<b>3,088.0</b>	<b>1</b>	<b>142.8</b>	-	-	-	-

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тус цэцэрлэгийн Ахмадын тухай хуулийн 14.7 заасан "Төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" заалтыг зөрчиж ахмадын сан байгуулаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>